



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 01579

Хэрлэн сум

Хөдөлгөөнт удирдлагын
байрны бэлэн байдлыг хангахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Болзошгүй гамшиг, ослын үед удирдлага зохион байгуулалтаар хангах, гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэх “Хөдөлгөөнт удирдлагын байр”-ны техник хэрэгслийн бэлэн байдлыг хангахад 11,500,000 (арван нэгэн сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэх техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, “Хөдөлгөөнт удирдлагын байр”-ыг бэлдэж бэлэн болгохыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 11 дугаар сарын 17-ны
А/579 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Байгууллагын нэр	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг, л	Үнэ
1	Аймгийн онцгой комисс	Хөдөлгөөнт удирдлагын байрны пүткэ	1	10,500,000
		Шатахуун	390 л	1000,000
Нийт				11,500,000